

ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ХӨТӨЛБӨРТ ТУССАН 14 МЕГА ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА, ҮР ДҮН, ЯВЦЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

1.1 Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам

📌 **Зорилго:** Экспортын хүчин чадал нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал хэмжээг 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэх.

💰 **Санхүүжилт:** БНХАУ-ын Эксим банк, гадаадын шууд хөрөнгө оруулалт.

Нийт төсөв: 868.589 тэрбум ₮ (Эрдэнэс Тавантолгой ХК)

🎯 **Хүрэх үр дүн:**

- Экспортын орлого **2 дахин нэмэгдэнэ.**
- Тээврийн зардал **50% буурна.**
- Төмөр замаар нүүрс тээвэрлэх хүчин чадал **3 дахин нэмэгдэнэ.**

⚡ **Ач холбогдол:** Эдгээр төслийг хэрэгжүүлснээр экспортын хүчин чадал 20 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, логиستيкийн зардал буурах боломж бүрдэнэ.

📌 **Гэрээний нөхцөл:**

- ✓ Хил дамнасан төмөр замыг хамтран барих - бүтээн байгуулалтын ажлыг нэг зурагтай, нэг гүйцэтгэгчээр богино хугацаанд хэрэгжүүлэх
- ✓ Нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх – олборлолтын хэмжээ
- ✓ Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ – үнийн механизм тогтох

✅ **Хийгдсэн ажил:** Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг холбох Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурж, УИХ-ын чуулганаар гэрээг соёрхон баталсан. Иж бүрэн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан.

⚠️ **Хүлээгдэж буй ажлууд:** Гэрээний нөхцөлийг тохирч, бүтээн байгуулалтын ажлыг нэг зурагтай, нэг гүйцэтгэгчээр богино хугацаанд эхлүүлэх

1.2. ШИВЭЭХҮРЭН-СЭХЭЭ БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ **БАРИХ ТӨСӨЛ**

 **Зорилго:** Монгол Улсын төмөр замын тээврийн салбарыг хөгжүүлэх, дотоодын төмөр замын сүлжээг нэмэгдүүлэх, хилийн боомтын шинэ гарц бий болгох, уул, уурхай бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах

 **Санхүүжилт:** Төр-хувийн хэвшлийн түншлэл, Шууд хөрөнгө оруулалт.
Нийт төсөв: **207,667,090 сая ₮ (Шивээхүрэн төмөр зам ХХК)**

 **Хүрэх үр дүн:**

- Өнөөгийн экспортын тээврийн хэмжээг **10 сая.тн-оос 20 сая.тн** хүртэл нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Бүс нутаг болон төмөр замын тээвэрлэлтээс улсын төсвийн өнөөгийн **орлогыг 2-3 дахин нэмэгдүүлэх** боломжтой болно.
- Монгол Улсын экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, **нүүрсний тээврийн зардлыг 2.5-4 дахин бууруулна.**

 **Ач холбогдол:**

- Монгол Улсын экспортын бүтээгдэхүүн БНХАУ-ын нутгаар дамжин далайн чанд дахь зах зээлд хүрэх шинэ гарцыг бий болгоно.
- Нарийнсухайтын орд газраас уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэн экспортод гаргах шинэ хилийн гарц нээгдэх
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж шинээр 233 хүнийг ажлын байраар хангана.

 **Хийгдсэн ажил:** Ачилт буулгалтын чингэлэг терминалын талбайн барилга угсралт, бусад бүтээн байгуулалтын ажил болох төмөр замын доод, дээд бүтэц, ус зайлуулах байгууламж, гадна цахилгаан хангамж, барилга байгууламж гэрэлтүүлэг, дохиолол холбооны байгууламжийн ажлын барилга угсралтын ажил бүрэн дууссан.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Монголын талын бүтээн байгуулалт бүрэн дууссан бөгөөд Хятадын талаас хил хүртэлх төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх

1.3. ХАНГИ-МАНДАЛ БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ БАРИХ ТӨСӨЛ

 **Зорилго:** Улаанбаатар төмөр замын Замын-Үүд- Эрээн боомтоор нэвтэрч буй ачаа тээврийн ачааллыг бууруулж, экспорт болон транзит тээврийн урсгалыг нэмэгдүүлэх

 **Санхүүжилт:** Төр-хувийн хэвшлийн түншлэл, Шууд хөрөнгө оруулалт.
Нийт төсөв: **498,662,000 сая ₮ (Монголиан транслийн болон Монголиан транс лижостик ХХК түншлэл)**

 **Хүрэх үр дүн:**

- Өнөөгийн экспортын тээврийн хэмжээг **10 сая.тн-оос 20 сая.тн** хүртэл нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Бүс нутаг болон төмөр замын тээвэрлэлтээс улсын төсвийн өнөөгийн орлогыг 2-3 дахин нэмэгдүүлэх боломжтой болно.
- Монгол Улсын экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нүүрсний тээврийн зардлыг 2.5-4 дахин бууруулна.

 **Ач холбогдол:**

- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугатын аж үйлдвэрийн бүсэд зориулан экспортлох уул уурхайн бүтээгдэхүүнийг өнөөгийн байдлаар Замын-Үүд – Эрээн – Жинин – Хөх хот – Бугат чиглэлийн төмөр замаар тээвэрлэхэд энэхүү зайг 318 км-ээр дөт болгох давуу талтай
- Уурхайн амнаас эцсийн хэрэглэгч хүртэл битүүмжилсэн чингэлэг тээвэрлэлт хийгдэх боломж бүрдэнэ.
- Уул уурхайн бүтээгдэхүүний чанар, чийгшлийн алдагдал эрс буурна.
- Ухаалаг систем нэвтрүүлснээр тээвэрлэлтийн үйл ажиллагаа явагдаж бүхэлдээ оролцогч талуудын хяналтад орж итгэлцэл бий болно.

 **Хийгдсэн ажил:** Ханги өртөөний 720 хүний 6 блок ажилчдын амрах байр, 350 хүний гал тогооны барилга баригдсан. Номгон өртөөний ажилчдын амрах байр, барилга болон дохиолол төвлөрүүлэлт хориглолын байгууламжийн угсралт суурилуулалтын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан.

 **Хүлээгдэж буй ажлууд:** “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” 2004 оны Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмж тусгах.

2. ТӨМӨР ЗАМЫН ЗҮҮН КОРИДОР - “ЭРЭЭНЦАВ-ЧОЙБАЛСАН-БИЧИГТ” **ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ.**

 **Зорилго:** Монгол Улсын төмөр замын сүлжээг өргөжүүлж, олон улсын тээвэр, худалдааг хөнгөвчлөх

 **Санхүүжилт:** Гадаадын шууд хөрөнгө оруулалт (Урьдчилсан үнэлгээгээр 1.9 тэрбум ам.доллар)

 **Төслийн онцлох үр нөлөө:**

- Эрээнцав – Чойбалсан - Бичигт чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор экспортын хэмжээ 20-25 сая тонноор нэмэгдэнэ.
- Бичигт-Эрээнцав чиглэлийн төмөр замын коридор нь Орос, Хятадыг холбосон төмөр замаас даруй 500 км-ээр богино бөгөөд тонн тутмаас 12 ам.доллар хэмнэх боломжтой.
- Зүүн бүсийн төмөр зам баригдсанаар олон ордуудын нөөцийн ангилал нь геологийн нөөцөөс эдийн засгийн үр ашигтай нөөцийн ангилал руу шилжиж бүс нутгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах боломжтой юм.
- Монгол Улсаар дамжин өнгөрөх экспортын хэмжээ нэмэгдэж, Европ-Азийг холбосон транзит тээврийн шинэ гарц бий болж, эдийн засагт онцгой ач холбогдол үзүүлнэ.

 **Хүрэх үр дүн:** Дорнод, Сүхбаатар аймгуудын нутгаар дамжин өнгөрөх бөгөөд “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Эрээнцав-Чойбалсан чиглэлийн 238 км төмөр замтай холбогдоно.

 **Хийгдсэн ажил:** “Монголын төмөр зам” ТӨХК болон Японы Улсын “Ниппон коей” ХХК-уудын 2013 онд хамтран боловсруулсан “Монгол Улсын шинэ төмөр замын төслийн туслалцааны зөвлөх үйлчилгээ”-ний Зураг төслийн тайлан дах техникийн үзүүлэлтэд тулгуурлан санхүүгийн тооцооллыг шинэчлэн боловсруулж, “УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ”-г хийсэн. Эрээнцав – Баянтүмэн чиглэлийн төмөр замын шугамыг Хөөт-Бичигт, Хөөт – Чойбалсан чиглэлийн шинээр байгуулагдах төмөр замын шугамтай холбон ачааг тээвэрлэх хүрээнд шинэчлэн хүчжүүлэх арга хэмжээний техникийн нөхцөлийн урьдчилсан судалгааг УБТЗ ХНН хийсэн. “Улаанбаатар төмөр зам” ХНН нь өөрийн харьяа “Эрээнцав-Чойбалсан” чиглэлийн зам шинэчлэлтийн замын их засварын зураг төсөл боловсруулалтын ажлыг хийж дуусгасан.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх.

3. Монгол-Францын хамтарсан ураны төсөл

 **Зорилго:** Ногоон эрчим хүч болох цөмийн эрчим хүчний үндсэн түүхий эд 68.9 мянган тонн ураныг үйлдвэрлэж, нүүрсэнд суурилсан цахилгаан станцуудтай харьцуулахад улс орнуудын хүлэмжийн хийн ялгарлыг 3.9 тэрбум тонноор бууруулж, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэнэ

 **Санхүүжилт:** БНФУ-ын ЗГ-ын шууд хөрөнгө оруулалт (Нийт төсөв: 1,6 тэрбум ам доллар)

 **Хүрэх үр дүн:** Жилд 2500 тн ураныг нийт 33 жилийн хугацаанд үйлдвэрлэх ба төслийн нийт хугацааны турш улс, орон нутагт төлөх татвар 5.2 тэрбум ам.доллар төвлөрүүлнэ.

 **Ач холбогдол:** Франц, Европын Холбооны стандартад нийцсэн уран олборлох шинэ техник технологи, нөү хау-г Монголд нутагшуулж, шинэ төрлийн үйлдвэр баригдах, нарийн мэргэжлийн, өндөр үнэлэмжтэй 1600 мэргэжилтэн бэлтгэж, монгол иргэдээс чадварлаг хүний нөөц бүрдүүлнэ.

 **Хийгдсэн ажил:** Зөөвч-Овоо ураны ордын үйлдвэрлэлийн туршилтын ажил дууссан. Зөөвч-Овоо ордод явагдсан үйлдвэрлэлийн туршилтаар ураныг газрын дор уусган олборлох технологиор олборлон нийт 10.5 тонн цэвэр уран бүхий 27.5 тонн эцсийн бүтээгдэхүүн /шар нунтаг/ олборлож 4 контейнер 123 торх ураны баяжмал төслийн талбайд хадгалагдаад байна.

- Монгол Улсын Их хурлын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дугаар тогтоолоор Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулан тогтоосноор Зөөвч Овоо, Дулаан Уулын ордуудын техник, эдийн засгийн үндэслэлийг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Эрдэс, баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталсан.
- Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г байгуулсан.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг хангаж, үндсэн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг 2025 оны эхний хагасаас эхлүүлэх нарийвчилсан инженерийн зураг төсөл хийлгэн, бүтээн байгуулалтыг цаг тухайд нь эхлүүлэхээр төлөвлөж байна. Төслийн Хөрөнгө оруулалтын гэрээний араас бусад дагалдах гэрээний ажил үргэлжилж байна.

4. Газрын тос боловсруулах үйлдвэр

 **Зорилго:** Тус төслийг хэрэгжүүлснээр импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан, уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.

 **Санхүүжилт:** БНЭУ-ын Эксим банк, Монгол Улсын Хөгжлийн банк, Эрдэнэс Тавантолгой ХК (Нийт төсөв: 1.9 тэрбум ам. доллар)

 **Хүрэх үр дүн:** Шатахууны дотоодын хэрэгцээний 55-60 хувийг хангана. Нефть-химийн аж үйлдвэрийн шинэ салбар бий болно. Жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авна.

 **Ач холбогдол:** Нефть-химийн аж үйлдвэрийн шинэ салбар бий болно. Түлш, шатахууны импортын хамаарлаас гарна.

 **Хийгдсэн ажил:** “Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэн хүлээн авч менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2019 оны 05-р сарын 13-ны өдөр “Engineers India Limited” компанитай байгуулж, үйлдвэрийн инженерчлэл, зураг төслийн ажлыг эхлүүлсэн.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн нийт өртгийг 1 тэрбум 698 сая ам доллар болгож 462.2 сая ам доллароор нэмсэн нэмэлт санхүүжилтийн гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Монгол улсын Сангийн яам, БНЭУ-ын Экспорт-Импортын банк хооронд үзэглэсэн.

 **Хүлээгдэж буй ажлууд:** “Монгол улсад Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн бүтээн байгуулалтыг дэд бүтцийн дараалал, барилга байгууламж тус бүрийн төвөгшил болон инженерчлэлийн ажилд зарцуулагдах хугацааг тооцсоны үндсэн дээр 2028 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

5. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц

📌 **Зорилго:** Баруун бүсийн эрчим хүчний хараат байдлыг арилгах.

💰 **Санхүүжилт:** БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл. (Нийт төсөв: 1,2 их наяд төгрөг)

2025 онд 79.9 сая ам доллар зарцуулахаар төлөвлөсөн.

🎯 **Хүрэх үр дүн:** Усан сан үүсгэснээр **1,14 тэрбум м3** хэмжээний цэвэр усны нөөц бүрдэж, жилд 366 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Хүлэмжийн хийг жилд ойролцоогоор 756.6 мянган тонн нүүрс шатаасантай тэнцэх хэмжээний 1.3 сая тонн нүүрсхүчлийн хийн ялгаралтыг бууруулна.

⚡ **Ач холбогдол:** Баруун бүсийн аймгуудын эрчим хүчний хангамжийг сайжруулна

✅ **Хийгдсэн ажил:** Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 160 дугаар тогтоолоор “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих” төслийн санхүүжилтийг БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих” төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээрийг байгуулахад шаардлагатай баримт бичгийн бүрдлийг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр БНХАУ-ын Экспорт-Импорт банканд хүргүүлснээр банкны зээлийн судалгаа буюу төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээр байгуулах бэлтгэл ажил эхэлж, 2023 оны 03 дугаар сарын сүүлээр тус банкны төлөөлөл төслийн талбарт ирж ажилласнаар төслийн үнэлгээний ажил эцэслэгдэж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан.

⚠️ **Хүлээгдэж буй ажлууд:** Ашиглалтын далангийн суурийн ажил, кемпийн байр, хүнд даацын автомашин өнгөрүүлэх гүүр, хоолой, кольц, техник засварын цехийн талбай болон байгаль орчин, археологи, палеонтологийн хайгуул судалгаанууд хийгдэж дууссан. 2025 онд БНХАУ-ын Эксим банкны 79.9 сая ам долларын санхүүжилтээр үндсэн зураг төсөл, барилга угсралтын ажлууд хийгдэхээр төлөвлөж байна.

6. Тавантолгой 450 МВт-ын дулааны цахилгаан станц

 **Зорилго:** Өмнөд бүсийн уул уурхайн эрчим хүчний хэрэгцээг дотоодоос хангах.

 **Санхүүжилт:** Төрийн өмчит ААН-ийн хөрөнгө оруулалт, Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэр (Нийт төсөв: 2,8 их наяд төгрөг)

 **Хүрэх үр дүн:** Говийн бүсийн стратегийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, тэдгээрийг дотоодын эрчим хүчний системээс хангаж, импортын эрчим хүчний хэрэглээг хязгаарлан жилд **120-140 сая ам. долларын** гадагш чиглэсэн валютын урсгалыг дотооддоо үлдээж, улс болон орон нутгийн төсөвт жилд 34.5 сая ам. долларын татвар, хураамжийг төвлөрүүлнэ.

 **Ач холбогдол:** Уул уурхайн бүсийн эрчим хүчний хангамжийг тогтвортой болгоно.

 **Хийгдсэн ажил:** “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК нь төслийг эхлүүлэхэд шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл холбогдох судалгаа тооцоолол, зөвшөөрөл, техникийн нөхцөл, газар эзэмших эрх авах зэрэг бэлтгэл ажлуудыг бүрэн хангасан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 132 дугаар “Тавантолгой дулааны цахилгаан станц төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” тогтоолоор төслийг 300МВт+150МВт гэсэн 2 үе шатад хуваан, эхний ээлжид 300МВт-аар төслийн барилга угсралт болон санхүүжүүлэх эх үүсвэрийг хамтатган (EPC+F) хэлбэрээр зохион байгуулах, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Төслийн санхүүжилтийн хувилбарыг эцэслэж, хөрөнгө оруулалтын хэлэлцээр зохион байгуулах

7. Нүүрс-хими, кокс-химийн цогцолбор

 **Зорилго:** Metallургийн үйлдвэрлэлийг эх орондоо хөгжүүлэх, улмаар гарган авсан коксыг өндөр үнэтэйгээр экспортлох боломж бий болгохоос гадна коксын үйлдвэрлэлийг дагалдан хөгжүүлэх шаардлагатай химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

 **Санхүүжилт:** Төр, хувийн хэвшлийн түншлэл (Нийт төсөв: 2,7 их наяд төгрөг)

 **Хүрэх үр дүн:** Кокс эрчим хүчний үйлдвэр нь 2.7 сая тонн баяжуулсан нүүрсийг боловсруулж 2 сая тонн кокс боловсруулж, 1.7 МВт эрчим хүч үйлдвэрлэнэ.

 **Ач холбогдол:** Дагалдах бүтээгдэхүүнийг боловсруулж төрөл бүрийн химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж химийн үйлдвэрлэлийн түүхий эдийг дотооддоо хангах боломжийг бүрдүүлэх. Харин кокс-химийн үйлдвэрийн хувьд эрчим хүчний хэрэглээнд коксыг боловсруулахад гарч байгаа бүтээгдэхүүнийг ашиглах нь эдийн засгийн хувьд үнэ цэнийг алдагдуулахаар, өөрөөр хэлбэл химийн үйлдвэрийн дагалдах үйлдвэрлэл, бүтээгдэхүүн бий болсноор химийн үйлдвэрлэл хөгжинө. Ингэснээр өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох, хувийн хэвшил, ЖДҮ-ийг дэмжих боломжийг бүрдүүлнэ.

 **Хийгдсэн ажил:** Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрээс гарч буй баяжмалыг цаашид боловсруулж эрчим хүч, кокс, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх кокс- химийн болон кокс-эрчим хүчний үйлдвэр, дулааны цахилгаан станц, давирхай болон хий боловсруулах үйлдвэрүүд мөн сэргээгдэх эрчим хүчний нөөц, эх үүсвэрийг ашиглах нар, салхины эрчим хүчний үйлдвэр, хаягдал бүтээгдэхүүн ашиглах үнс иж бүрэн боловсруулах, ус цэвэршүүлэх үйлдвэрүүдийг Тавантолгой ҮТП-ийн төслийн хүрээнд үе шаттайгаар бүтээн байгуулахаар төлөвлөсөн.

 **Хүлээгдэж буй ажлууд:** “Нүүрс-химийн цогцолбор” төслийн хүрээнд нийгэм, эдийн засагт өндөр ач холбогдолтой “Хөх нүүрсний үйлдвэр”-ийн эхний шатыг 2026 онд барьж ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Дайвар бүтээгдэхүүнээр стратегийн бүтээгдэхүүнүүд, эрчим хүч, химийн түүхий эд үйлдвэрлэнэ. Төслийн хүчин чадал нийт 850 мянган тонн хөх нүүрс, 77 мянган тонн давирхай, 880 сая кВт эрчим хүч үйлдвэрлэх тооцоолол хийж шаардагдах хөрөнгө оруулалт 190 сая ам доллар байхаар тооцсон байна.

8. Зэс боловсруулах үйлдвэр

📌 **Зорилго:** Жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 125 мянган тонн катодын зэс, 72 кг алт, 38.2 тонн мөнгөн гулдмай болон 182 мянган тонн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ

💰 **Санхүүжилт:** Төрийн өмчит ААН-ийн хөрөнгө оруулалт, Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэр (Нийт төсөв: 2,6 их наяд төгрөг)

🔄 **Хүрэх үр дүн:** Катодын зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр үзүүлнэ. Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ

⚡ **Ач холбогдол:** Тухайн цогцолборт хэрэгжих боломжтой шинэ шинэ төслүүдийн ашигт ажиллагаанаас шалтгаалж, тасралтгүй өсөн нэмэгдэх бүрэн боломжтойн дээр ажлын байр нэмэгдүүлэх, гадаад дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг татах, урт хугацаанд үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн бодит хэрэгжилтийг хангах суурь нөхцөлийг бий болгоно.

✅ **Хийгдсэн ажил:** Зэсийн баяжмал, хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн хувьд Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших Эрдэнэт үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд хэрэгжинэ. Дэд бүтцийн бүтээн байгуулалтын нийт санхүүжилт 69.96 сая.ам доллар төлөвлөгдсөнөөс 12.62км авто замын бүтээн байгуулалт 4.2 сая ам.доллар, 4.4 км төмөр замын бүтээн байгуулалт 7.32 сая ам.доллар, ус хангамжийн бүтээн байгуулалт 11.64 сая ам.доллар, паркийн гадна хашаа 1.14 сая ам.доллар буюу нийт 24.3 сая ам.доллар хөрөнгө оруулалт хийгдээд байна. Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрийн төслийн ерөнхий төлөвлөгөө, дэд бүтцийн эх үүсвэрийн судалгаа боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

⚠️ **Хүлээгдэж буй ажлууд:** Энэ оны 2 дугаар улиралд багтаан ерөнхий гүйцэтгэгч сонгон шалгаруулах ЕРС тендерийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. 2025 онд 264 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгдсөн ба хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, худалдан авалтыг 1 эх үүсвэрээр хийх болон эрх зүйн орчны шинэчлэлт хийх зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

9. Орхон-Онги, Хэрлэн-Тоонот ус дамжуулах хоолой барих

 **Зорилго:** Экологийн төслийн үр ашгийг дээшлүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, говийн бүсийн уул уурхайн өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг хангах

 **Санхүүжилт:** Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэр (Нийт төсөв: 2,7 их наяд төгрөг)

 **Хүрэх үр дүн:** Хүлэмжийн хийн ялгарлыг 30 мянган тонн оор бууруулж, 51.6 тэрбум м3/с цэвэр усыг хуримтлуулна.

 **Ач холбогдол:** Говийн бүс нутаг дахь эдийн засгийн хөгжил, хуурайшилтыг багасгах, нэмэлт усны нөөц нь хот суурин газар руу чиглэх хүн амын төвлөрөлтийг багасгах, хүн ам, хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах усны хэрэглээг хангах, цөлжилтийг бууруулах, отор нүүдлийг багасгах олон талын ач холбогдолтой.

 **Хийгдсэн ажил:** Орхон голоос Онги голын урсац нэмэгдүүлэх замаар Улаан нуурыг сэргээх, улмаар Говийн бүсийн усны нөөцийг нэмэгдүүлж тухайн бүс нутгийн усны хэрэгцээг хангах зорилго бүхий “Орхон-Онги” төслийн техник эдийн засгийн үндэслэлийг 2020-2021 онд боловсруулж барилгын ажлын зураг төсөл, судалгаа тооцооллын ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Орхон-Онги” төслийн ТЭЗҮ-г үр өгөөж, ач холбогдлоор нь экологийн болон эдийн засгийн төсөл хэлбэрээр 2 ангилан санхүүжилтийн схемийг боловсруулсан байсан бөгөөд бид бэлэн байгаа ТЭЗҮ-нд түшиглэн уг төслийг хурдтай эхлүүлэх санхүүгийн болон 2 улсын хилийн усны асуудалгүй дотооддоо шийдэж хамгийн хурдан явуулах боломжтой хэлбэрээр хөрөнгө оруулалт санхүүгийн хэд, хэдэн хувилбарыг боловсруулсан.

“Хэрлэн-Тооно” төслийн ТЭЗҮ-ийн тодотгол, ажлын зураг төсөл, төсөв хийх, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай 3 сая.долларын санхүүжилтийн асуудлыг “Эрдэнэс-Оюутолгой” ХХК шийдвэрлэн нэмэлт тодотгол хийх ажил явагдаж байна.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Энэ оны 2 дугаар улиралд багтаан тендерийн баримт бичиг боловсруулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах

10. Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц

 **Зорилго:** Оргил ачааллын үед импортыг орлож бүс нутгийн эрчим хүчний хараат байдлыг шийднэ.

 **Санхүүжилт:** Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэр (Нийт төсөв: 3,7 их наяд төгрөг)

 **Хүрэх үр дүн:** Усан сан үүсгэснээр 5.7 тэрбум м3 хэмжээний цэвэр усны нөөц бүрдэж, жилд 606 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438,7 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулна.

 **Ач холбогдол:** ОХУ-д жил бүр төлдөг 45-50 сая ам. долларын импортын төлбөрийг хэмнэнэ. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд горим тохируулгын эх үүсвэр бий болно.

 **Хийгдсэн ажил:** Эгийн голын УЦС төслийн Байгал нуур, Сэлэнгэ мөрөнд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэх Орос-Монголын хамтарсан шинжээчдийн багийн дүгнэлтийг 2026 оны эхний хагаст гаргахаар төлөвлөж байна. Тус ажлын хүрээнд Монгол Улс болон ОХУ-ын Шинжлэх Ухааны Академиуд хамтран Сэлэнгэ мөрний экологийн урсцыг хангасан ашиглалтын горимын хувилбарыг санал боловсруулах зорилгоор "Эгийн голын усан цахилгаан станц" төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажлыг Монгол-Оросын экспертийн ажлын хэсэг хамтран хийхээр тохирсон.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар "Эгийн голын усан цахилгаан станц" төслийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцсэн бөгөөд туслах боомт болон үндсэн ТЭЗҮ-ийн нэмэлт судалгааны ажилд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэсэн.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Санамж бичгийн хүрээнд байгуулагдсан Эгийн голын УЦС төслийн Байгал нуур, Сэлэнгэ мөрөнд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэх Орос-Монголын хамтарсан шинжээчдийн багийн дүгнэлтийг 2026 оны эхний хагаст гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд хээрийн судалгааг 2025 онд эхлүүлэхээр ажиллаж байна.

11. Гангийн цогцолбор

 **Зорилго:** Тус төслийг хэрэгжүүлснээр дотоодын тасралтгүй нэмэгдэж байгаа ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

 **Санхүүжилт:** Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэр (Нийт төсөв: 2,2 их наяд төгрөг)

 **Хүрэх үр дүн:** Эхний ээлжид 100.0 мянган тн хүчин чадалтай шууд ангижруулах төмрийн үйлдвэрийг барьснаар “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааг тогтвортой болгож, цаашлаад 1.2 сая тн ган хайлуулах үйлдвэрийг барьж байгуулах

 **Ач холбогдол:** Эдгээр үйлдвэрүүд ашиглалтад орсноор энэ төрлийн бүтээгдэхүүнүүдээс хамаарах гадагшаа чиглэсэн валютын урсгалыг хязгаарлах, зарим төрлийн нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнүүдээс нэмэлт экспортын орлого олох боломжтой болох юм.

 **Хийгдсэн ажил:** Гангийн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулахад шаардлагатай газрын асуудлыг урьдчилсан судалгаагаар инженер-геологи болон дэд бүтцийн нөхцөл байдал дээр үндэслэн шийдвэрлэж, Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт харьцангуй давуу талтай гэж дүгнэсэн. Төслийн хүрээнд хэрэгжих шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Эрдэнэс ҮТП ХХК-ийн инженер, техникийн ажилчид боловсруулан ЭБМЗ-ийн Боловсруулах үйлдвэрлэлийн өргөтгөсөн, салбар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулаад байна. Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийн хөгжлийн төлөвлөгөөг Эрдэнэс ҮТП компанийн зүгээс боловсруулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны паркийн зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Санхүүжилтийн эх үүсвэрийн хувилбаруудыг судалж хөрөнгө оруулалтын гэрээг ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, бүтээн байгуулалт, ашиглалт гэсэн концепцийн хүрээнд байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

12. Алт цэвэршүүлэх үйлдвэр

 **Зорилго:** Алт цэвэршүүлэх үйлдвэрийг дотооддоо байгуулж ашиглалтад оруулснаар Монгол Улсын газрын хэвлий доорх алт, мөнгө, үнэт металлыг өөрсдөө боловсруулж, дэлхийн стандартад нийцсэн алтан болон мөнгөн гулдмай, бэлэг дурсгалын гулдмай, үрэл, ялтас зэрэг цэвэршүүлсэн бүтээгдэхүүн дотооддоо үйлдвэрлэж эхлэх юм.

 **Санхүүжилт:** Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэр

 **Хүрэх үр дүн:** Алтыг дотооддоо цэвэршүүлж, мөнгөжүүлэх

 **Ач холбогдол:** Монгол улсын эрдэнэсийн санг арвижуулах, гадаад валютын улсын нөөц нэмэгдүүлэх, төгрөгийн ханш тогтворжуулахад чухал үүрэгтэй.

 **Хийгдсэн ажил:** Алт цэвэршүүлэх үйлдвэр манай улсын хувьд эдийн засгийн төдийгүй үндэсний аюулгүй байдлын ач холбогдолтой. Тиймээс Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2019 оны 2 дугаар сард зөвлөмж гаргасны дагуу стратегийн ач холбогдол бүхий төслийн жагсаалтад оруулсан. Төслийн байршлын хувьд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу Толгой ордыг түшиглэн байгуулахаар судалж байна.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Санхүүжилтийн эх үүсвэрийн хувилбаруудыг судалж хөрөнгө оруулалтын гэрээний загварыг боловсруулах

13. Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр барих

 **Зорилго:** Эрчим хүчний импортын цахилгаан хэрэглээг бууруулж бүс нутгийн эрчим хүчний хангамж сайжирна.

 **Санхүүжилт:** Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэр (Нийт төсөв: 2,5 их наяд төгрөг)

 **Хүрэх үр дүн:** Нар, салхины эх үүсвэрээс **1.38 тэрбум кВт.ц** эрчим хүч үйлдвэрлэнэ. Нар, салхины эх үүсвэрээс 1 кВт.ц-ын тариф 4-5 цент буюу хямд үнэ бүхий цэвэр эрчим хүчээр хэрэглэгчдийг хангах боломжтой.

 **Ач холбогдол:** Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 586,5 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг салхин станц 693,6 мянган тонн, нарны цахилгаан станц 244,8 мянган тонноор тус тус бууруулна.

 **Хийгдсэн ажил:** “Нарны цахилгаан станцын төсөл”-ийн төслийг өрсөлдөөнт худалдан авалтын аргаар зохион байгуулахаар “Европын сэргээн босголтын банк”-тай хамтран ажиллаж нэгдсэн сүлжээнд холбох оновчтой байршлыг тогтоон, холбогдох ажлуудыг зохион байгуулсан. Судалгааны үр дүнд нарны цахилгаан станцыг тархмал байдлаар хэрэгжүүлэх боломжтой үр дүн гарсан. Нарны эх үүсвэрийг нийт бүс нутгийн хэмжээнд үе шаттайгаар хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд цахилгаан дамжуулах сүлжээний нэвтрүүлэх чадвар, системийн шингээх боломжийн талаарх судалгааг “ДҮТ” ТӨХХК-тай хамтран боловсруулж байна.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Тус тооцоо, судалгааны үр дүнд үндэслэн төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба төслийг сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

14. Үндэсний хиймэл дагуул

 **Зорилго:** Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулыг хөөргөснөөр Монгол Улсын газар нутгийг бүрэн хамарсан, орон зайн ялгаваргүй харилцаа холбооны бие даасан сүлжээ үүсгэж интернэт суурьтай бүх төрлийн харилцаа холбооны үйлчилгээг бүх иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх боломжийг нээнэ.

 **Санхүүжилт:** Улсын төсөв болон БНФУ-ын нэн хөнгөлөлттэй зээл (Нийт төсөв: 1,1 их наяд төгрөг)

 **Хүрэх үр дүн:** Гамшгийн ослоос шалтгаалж амиа алдах хүмүүсийн тоог 30 хувь бууруулна; Агаарын бохирдлыг хэмжинэ; Зудын гамшиг 10 хувь буурна; Ой хээрийн түймэр 10 хувь багасна; Алслагдсан бүс нутгийн эрүүл мэндийн зардал 10 хувь буурна; Боловсролын ялгаа 50 хувиар багасна.

 **Ач холбогдол:** Жил бүр транспондер түрээслэн телевиз, интернэт, хөдөлгөөнт холбооны сүлжээ, харилцаа холбооны үйлчилгээг алс зайд дамжуулахад ашиглахад гаргаж байгаа зардлыг хэмнэж, дотоодын зах зээлд үлдээх боломж бүрдэнэ.

 **Хийгдсэн ажил:** Өнгөрсөн хугацаанд Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас сансар дахь байршлыг гурван удаа баталгаажуулсан бөгөөд 2027 онд хиймэл дагуулаа бүтээж дуусган, сансрын уудам орон зайд гаргахаар төлөвлөсөн.

 **Хүлээгдэж буй ажлууд:** Санхүүжилтийн эх үүсвэрийн хувилбаруудыг судалж, нэмэлт судалгааны ажил хийх
